# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

**2020 оны 51 болон 52 дэх долоо хоног**

# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 12-р сарын 18-аас 12-р сарын 31-ний байдлаар

Улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын шийдвэр, арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 30 дахь дугаарыг хүргэж байна. Энэ удаагийн дугаарт БРЕКСИТ буюу Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (Их Британи) Европын Холбооноос гарсан үйл явцыг онцолж байна.

## 1 ИХ БРИТАНИ УЛС ЕВРОПЫН ХОЛБООНООС ГАРАВ

Европын холбооноос гарах буюу Брексит тус улсын нийгэмд дэмжлэг авах хэд хэдэн гол шалтгаан байв. Үүнд:

- **Бүрэн эрхт байдлаа хамгаалах:** Эдийн засгийн өрсөлдөөний бодлого, хөдөө аж ахуй, зохиогчийн эрх, патентийн хууль болон бусад хуулийн асуудлуудын хувьд ЕХ-ны журам нь тус холбооны гишүүн орнуудын хууль эрх зүйн баримт бичгүүдээс давуу байдаг. Энэ нь Их Британийн бүрэн эрхт байдлыг хязгаарладаг гэсэн үзэл Брекситийг дэмжих бас нэг шалтгаан болж байв. Тухайлбал, Европын хүний эрхийн эрх зүйн тогтолцоо нь Европын нэгдсэн журмаар явдаг бөгөөд үүний нөлөөгөөр харийн гаралтай хүнд гэмт хэрэгтнүүдийг албадан гаргахад хүндрэлтэй байдаг зэрэг асуудлууд үүсч байв.
- **Европын Холбоонд өгч буй хандив тусламжийн мөнгийг хэмнэх**: Их Британи ЕХ-ны гишүүн улс орнуудад 2008 онд 2.7 тэрбум фунт стерлингийн цэвэр хандив тусламж өгч байсан бол 2013 онд уг дүн 11.3 тэрбум фунт стерлинг болж өсчээ. Брекситийг дэмжигчид ЕХ-ны улс орнуудад дэмжлэг үзүүлэх нь Их Британийн хувьд үр өгөөжгүй, татвар төлөгчдөд дарамт болдог гэж үздэг.
- **Бусад орнуудаас ирэх цагаачлалыг хязгаарлах**: Брекситийг дэмжигчдийн гуравны нэгийн хувьд цагаачлалын асуудал ЕХ-ноос гарах гол шалтгаан байв[1]. ЕХ-ны ажиллах хүчний чөлөөтэй шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр сүүлийн 10 гаруй жилд Зүүн Европын орнуудаас Их Британид шилжин суурьшигчдын тоо эрс өслөө. Цагаач иргэд Засгийн газрын халамж, тэтгэмжийг хүртэхийн зэрэгцээ Их Британи улсын иргэдийн ажлын байрыг булааж байна гэдэг үзэл Брекситийг дэмжих нэг гол шалтгаан болж байв.

[1] “The Economist” сэтгүүлд 2016 онд мэдээлснээр Брекситийг дэмжигчдийн 94 хувь нь 2001-2014 оны хооронд цагаачлагчдын тоо 200 гаруй хувиар өссөн бүсүүдийн сонгогчид байжээ.

## 2 БРЕКСИТ ЭХЭЛСЭН ЦАГААС ХОЙШ ГАРСАН ШИЙДВЭРҮҮД БОЛОН ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧОО

Брексит нь нэг удаагийн үйл явдал гэхээсээ илүүтэй урт хугацааны үйл явц юм. Их Британи ЕХ-нд нэгдсэнээс хойш 40 гаруй жилийн дараа улс төр, хууль эрхзүй, эдийн засгийн олон талт харилцааг тусгаарлах тохиролцоонд хүрэх, ингэхдээ аль аль талуудын ашиг сонирхлыг харгалзан шийдэлд хүрэх, сонгогчдод өгсөн амлалтыг алдагдуулахгүй байх, эдийн засгийн хувьд хохирлыг бага байлгах (худалдааны хэлэлцээрт хүрэх), эрхзүйн баримт бичгүүдийг батлах зэрэг олон асуудлууд байсан нь Их Британи ЕХ-оос салан тусгаарлах процессыг илүү удаан, төвөгтэй болгосон.

**2016**

6/23-нд Их Британийн бүх нийтийн санал асуулгаар ард иргэдийн дийлэнх нь Европын Холбооноос гарах санал өгөв.

7/11-нд Ерөнхий сайд Тереза Мэй Консерватив намаас Ерөнхий сайдаар томилогдов.

10-р сард Их Британи ЕХ-ны тухай гэрээний 50 дугаар зүйлд (Article 50)* заасны дагуу ЕХ-оос 2017 оны 3-р сард гарахаа зарлав.

**2017**

3-р сард Их Британи ЕХ-оос гарах хүсэлтээ албан захидлаар мэдэгдэв.

5-р сард Европын Комисс хэлэлцээрийн удирдамжийг зарлав.

7-р сард Брюссель хотноо ЕХ болон Их Британийн төлөөлөгчдийн албан ёсны хэлэлцээр эхлэв.

9-р сард Ерөнхий сайд Т.Мэй Флоренцод тавьсан илтгэлдээ Их Британи төсвийн амлалтаа биелүүлэхээ амлаж НҮБ-ээс зөвлөсөн зорилт болох үндэсний нийт орлогын 0.7 хувийг Хөгжлийн албан ёсны тусламжид зарцуулах, Брекситийн дараах 2 жилийн шилжилтийн үеийг санал болгов.

**2018**

3/2-нд Брекситийн хэлэлцээрт Их Британийн талаас ажиллах хүчний чөлөөт шилжилт хөдөлгөөн, хандивын төсөв, Европын Шүүхийн үүрэг, гадаад худалдаа, загас агнуур зэрэг томоохон бодлогын салбаруудад их хэмжээний буулт хийхээр байгааг Ерөнхий сайд Т.Мэй "Mansion House"-д тавьсан илтгэлдээ онцлов

3/19-нд Их Британи ЕХ-г орхих гэрээний төсөл бэлэн болсон ч бүрэн хэлэлцээрт хүрээгүй.

7/12-нд “Chequers Plan*” нэртэй Их Британи болон ЕХ-ны ирээдүйн харилцааны талаарх дүрмийн баримт бичгийг олон нийтэд ил болгов.

9/21-нд Австрий Зальцбург холод болсон хэлэлцээрт талууд зөвшилцөлд хүрч чадаагүй. Гол шалтгаан нь Бүгд Найрамдах Ирланд Улс болон Хойд хилийн хяналт, худалдааны асуудал байв.

11/25-нд Их Британи болон ЕХ нь Их Британийн зүгээс тавьсан нөхцөлүүд дээр тохиролцоонд хүрэв.
ЕХ-ны удирдагчид Брюссель хотноо болсон дээд хэмжээний уулзалт дээр гарын үсэг зурсан ч гэрээ хүчин төгөлдөр болохын тулд УБУИНВУ болон Европын Парламентуудын зөвшөөрлийг асах шаардлагатай бай. Гэвч Ирландын хилийн нөхцөлөөс болж зөвшөөрөгдөөгүй.

**2019**

3/20-нд Брекситийн хэлэлцээр дуусах хугацааг 3/29-өөс 6/30-н хүртэл сунгах хүсэлт гаргав. 3/21-нд ЕХ-ноос 2 хувилбарыг санал болгов: Хэлэлцээрт хүрч чадвал 5/22-н хүртэл, үгүй бол 4/12 хүртэлх хугацааг өгөв.

4/10-11-нд Брекситийг эцэслэх хугацааг дахин сунгахыг хүсч, ЕХ-ны удирдагчид хугацааг 10/31 хүртэл сунгав.

8/19-нд Ерөнхий сайд Б. Жонсон ЕХ-нд Ирландын хилтэй холбоотой асуудлыг хэлэлцээрийн нөхцөлүүдээс хасах хүсэлт албан ёсоор гаргасан ч ЕХ хүлээн аваагүй.

9/9-нд Их Британийн Парламент “Benn bill” актыг хүчин төгөлдөр болгож, тал талд ашигтай тохиролцоонд хүрээгүй цагт Их Британи ЕХ-ноос гарахааргүй болов.

10/3-нд Их Британийн ЗГ Брюссель руу шинэ гэрээний төлөвлөгөөг илгээв. ЕХ 3 хоногийн дараа төлөвлөгөөг түдгэлзүүлэв.

10/10-нд Их Британи болон ЕХ Брекситийн гэрээний тохиролцоонд хүрэв.

10/19-нд Британийн Парламентын гишүүд Брекситийн хэлцлийг хэрэгжүүлэх хуулийн төсөл батлагдтал гэрээг батлахаа азнахаар болов. Брекситийг эцэслэх хугацааг 2020/1/31 хүртэл сунгав.

**2020**

1/23-нд Их Британийн ЕХ-ноос гарах хэлцлийг хэрэгжүүлэх хуулиуд батлагдав. 1/29-нд Европын Парламент Их Британийг ЕХ-ноос гаргах гэрээг батлав.

1/31-нд **Их Британи ЕХ-ноос гарав**. Их Британи, ЕХ-ны цаашдын харилцааг цэгцлэх шилжилтийн үе эхлэв.

6/18-19-нд ЕХ-ны дээд хэмжээний уулзалтаар хэлэлцээрт хүрээгүй. 6/30-нд Шилжилтийн үеийг сунгахгүй байхаар шийдэв.

10/15-16, 12/10-11-нд ЕХ-ны дээд хэмжээний уулзалтаар чөлөөт худалдааны хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

12/24-нд ЕХны Комисс Их Британитай цаашдын хамтын ажиллагааны нөхцөлүүд дээр тохироцоонд хүрч, **"Худалдаа болон Хамтын Ажиллагааны Гэрээ"-г байгуулав.**

Их Британи болон ЕХ хоорондын улс төр, эдийн засгийн шинэ харилцаа эхэлнэ.

## 3 ЕВРОПЫН ХОЛБОО БОЛОН ИХ БРИТАНИЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Урт хугацааны туршид хэлэлцсэний эцэст Европын Холбооны Комисс Их Британитай цаашдын хамтын ажиллагааны нөхцөлүүд дээр тохиролцоонд хүрч, 2020 оны 12-р сарын 24-ны өдөр "Худалдаа, хамтын ажиллагааны гэрээ (Trade and Cooperation Agreement)"-г байгуулав. Тус гэрээ нь доорх үндсэн гурван тулгуур баримт бичгээс бүрдэж байна.

**1) Чөлөөт худалдааны гэрээ (A Free Trade Agreement):**

Тус гэрээнд зөвхөн бараа, үйлчилгээний худалдаа төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн шударга өрсөлдөөн, улсын дэмжлэг, татварын ил тод байдал, агаарын болон авто тээвэр, эрчим хүч, мэдээллийн аюулгүй байдал, нийгмийн хамгааллын зохицуулалт зэргийн талаар тусгасан.

- **Бараа:** "Барааны гарал үүслийн дүрэм (Rules of Origin)"-ийн дагуу бараг бүрэн үйлдвэрлэсэн, эсхүл үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн улс нь тодорхой бичиг баримттай бараанд тариф, квот ногдуулахгүй.
- **Тээвэр:** Их Британи ЕХ-ноос гарснаар "Single Market" буюу ЕХ-ны нэгдсэн зах зээлээс харьцангуй жижиг зах зээл рүү шилжиж байгаа хэдий ч тээврийн хувьд агаар, авто зам, төмөр зам, далайн тээврийг ямар нэг хязгаарлалтгүйгээр тогтвортой үргэлжлүүлэхээр заасан.
- Талууд амьд амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход шаардагдах амьтны эрүүл мэнд, био аюулгүй байдлын стандартыг бүрэн дүүрэн хангадаг тул зөвшөөрлийг өмнөхөөр нь үлдээв.
- **Загас агнуурын эрх:** Энэ эрхийн нөхцөл дээр Их Британи болон ЕХ 2026 оны 6 дугаар сар хүртэлх шилжилтийн хугацаанд доорхи тохиролцоонд хүрсэн. Энэ хугацаанд ЕХ, Их Британийн газар нутагт загасчлах боломжтой бөгөөд квотыг өмнөхөөс 25 хувиар бууруулав. Шилжилтийн үеэс хойш талууд жил бүр тохиролцоонд хүрч шийднэ.
- **Эрчим хүч:** Их Британи болон ЕХ нь хий болон цахилгаан эрчим хүчийг солилцохын зэрэгцээ маш олон технологийг хамтран хэрэглэж, хэд хэдэн эрчим хүчний компаниуд хоёр зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. Иймд талууд эрчим хүчийг олон улсын цахилгаан болон байгалийн хийн хангамжийн сүлжээгээр дамжуулан хамтран хэрэглэхээр тохиролцов. Гэрээнд мөн хоёр тал сэргээгдэх эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлээр

хамтран ажиллахыг үүрэг болгов. Парисын уур амьсгалын өөрчлөлтийн хэлэлцээрийн дагуу аль нэг тал амлалтаа зөрчвөл гэрээг түдгэлзүүлж болно. Цөмийн эрчим хүчний хамтын ажиллагааны тухайд тусдаа гэрээ байгуулна.

- Талууд байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, нүүрстөрөгч ялгаруулах эрхээ арилжаалах, нийгэм, хөдөлмөрийн эрхийн асуудал, татварын ил тод байдал, улсаас олгох дэмжлэг зэрэгтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.
- **Үйлчилгээ:** ЕХ-ны нэгдсэн зах зээлээс гарснаар Их Британи санхүүгийн үйлчилгээ эрхлэх зарим зах зээлийн эрхээ ч алдав. Их Британиас ЕХ руу экспортолж буй бүтээгдэхүүний 40 гаруй хувийг үйлчилгээ эзэлдэг бөгөөд нийт үйлчилгээний салбар нь Их Британийн эдийн засгийн үйл ажиллагааны 80 орчим хувийг эзэлдэг байна.
- ЕХ-ны нэгдсэн зах зээлд автоматаар нэвтрэх боломжийг олгодог гадаад паспортын эрх байхгүй болсноор “Мэргэжлийн ур чадварыг харилцан хүлээн зөвшөөрөх (Mutual Recognition of Professional Qualifications MRPQs)” статуст багтдаг эмч, инженер, архитектор зэрэг ЕХ-ны аль ч гишүүн улсад ажиллах боломжтой ажлууд хэрхэх нь тодорхой бус үлдэв. 2021 оны эхэн үеэр ЗГ-аас энэ талаар тодорхой чиглэл өгөхөөр заасан байна.
- **Мэдээллийн аюулгүй байдал:** Талууд дор бүрнээ мэдээлэл өгөгдлийн аюулгүйн дүрмүүд дээр шийдэлд хүрэх хүртэл түр хугацааны мэдээлэл солилцооны тусгай заалтыг оруулж өгсөн ба энэхүү заалт нь хамгийн дээд тал нь 6 сарын хүчинтэй.

2) **Иргэдийн аюулгүй байдлыг хангах шинэ хамтын ажиллагаа (A new partnership for our citizens' security):**

- Эрүү, иргэний эрх зүйн асуудлаар хууль хүчний болон шүүхийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээг шинэчлэн заасан. Үүнд цагдаа болон шүүхийн байгууллагууд хил дамнасан гэмт хэрэг, терроризмтой тэмцэхэд хамтран ажиллахаар заасан.
- Европын хүний эрхийн конвенцыг үргэлжлүүлэн дагаж мөрдөх, дотоодын хэрэгжилтийг хангах үүргийг Их Британи зөрчсөн тохиолдолд энэхүү аюулгүй байдлын хамтын ажиллагааг түдгэлзүүлж болно.

3) **Эрх тэгш засаглалын нөхцөлүүд (A Horizontal Agreement on Governance):**

- Талуудын бизнес эрхлэгчид, хэрэглэгчид болон иргэдэд эрх зүйн тодорхой байдлыг бий болгох үүднээс гэрээ хэрхэн хэрэгжих, хянагдах талаар тусгай бүлгийг оруулж өгсөн байна. Түүнчлэн гэрээг зохих ёсоор нь хэрэгжүүлж, тайлбарлаж, гарч байгаа бүх асуудлыг шийдвэрлэхэд Хамтарсан түншлэлийн зөвлөлийг (Joint Partnership Council) байгуулсан байна.
- Гэрээг дагаж мөрдөх, маргаан шийдвэрлэх заалтуудыг нэгтгэн зангидаж өгснөөр ААН, хэрэглэгч, хувь хүний эрхийг хамгаалахыг зорьжээ. ЕХ болон Их Британийн бизнес эрхлэгчдэд эдийн засгийн шударга өрсөлдөөнийг бүрдүүлж, аль нэг талд шударга бус татаас

авах, өрсөлдөөнийг гажуудуулахаас сэргийлэх боломжтой гэж үзжээ.

- Аль нэг тал тохиролцоог зөрчсөн тохиолдолд хоёр тал салбар хоорондын хариу арга хэмжээ (cross-sector retaliation) авах эрхтэй. Салбар хоорондын энэхүү хариу арга хэмжээ нь эдийн засгийн түншлэлийн бүхий л салбарт хамаатай.

## 4 2021 ОНЫ 1-Р САРЫН 1-НЭЭС ЯМАР ӨӨРЧЛӨЛТҮҮД БИЙ БОЛОХ ВЭ?

- **Ажиллах хүчний чөлөөт хөдөлгөөн хязгаартай болно**. 2021 оны 1-р сарын 1-ээс хэрэгжих Их Британийн цагаачлалын шинэ бодлогоор ЕХ-ны ажилчид Их Британид ажиллахын тулд ур чадвартай гадаад ажилчдыг татах оноонд суурилсан системийн дагуу ажиллах визний хүсэлт гаргадаг болно. Улмаар ЕХ-ны иргэд Их Британид чөлөөтэй шилжин суурьшиж ажиллах, Их Британийн иргэд ЕХ-ны орнуудад чөлөөтэй шилжин суурьшиж ажиллах эрхгүй, ажлын виз шаардлагатай болж байна.
- **Урт хугацаагаар аялах, амьдрахад виз хэрэгтэй болно**. Брекситийн өмнө Их Британийн иргэд ЕХ-ны орнуудад аялах, амьдрах боломжтой хугацааг тухайлан заагаагүй, хязгааргүй байсан бол 1-р сарын 1-ээс эхлэн Их Британийн иргэд ЕХ-ны орнуудад визгүй зорчих хугацаа 180 хоногийн дотор 90 хоног болж өөрчлөгдөнө[2]. ЕХ-ны орнуудын иргэд аяллын зорилгоор Их Британид 6 сар хүртэлх хугацаанд визгүй нэвтрэх боломжтой[3]. 2 талын иргэд энэ хугацаанд ажил эрхэлж болохгүй. 2022 оноос Их Британийн иргэд Шенгений орнууд руу электрон виз авч нэвтрэх шаардлагатай болно.
- **Гадаад бодлого, аюулгүй байдлын хамтын ажиллагаа хумигдана**. Их Британийн талаас хэлэлцээр хийхийг хүсээгүйн улмаас гадаад бодлого, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны талаар “Худалдаа, Хамтын Ажиллагааны Гэрээ”-нд тусгаагүй болно. Тиймээс 2021 оны 1-р сарын 1-ээс эхлэн гадаад бодлогын тулгамдсан асуудалд хамтарсан хариу арга хэмжээ боловсруулах, зохицуулах, гуравдагч орны иргэд эсвэл эдийн засагт хориг арга хэмжээ авах зэрэг асуудал дээр Их Британи, ЕХ-ны хооронд нэгдсэн зохицуулалт үгүй болж, талууд тусдаа асуудлаа шийдвэрлэх юм.
- **Үйлчилгээний экспорт, импорт хязгаарлагдана.** Худалдааны хэлэлцээрт үйлчилгээний гадаад худалдаа багтаагүй, Их Британи йн ажиллах хүчний ур чадварыг ЕХ өмнөхтэй адилаар шууд хүлээн зөвшөөрөхгүй тул Их Британийн үйлчилгээний сектор ЕХ-нд үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй болно[4]. Талуудын үйлчилгээ,

[2] Мөн Их Британийн иргэд Евро бүсийн орнуудын хилээр нэвтрэхэд гуравдагч орны иргэдтэй адилаар аюулгүй байдлын бүрэн нэгжлэг, шалгалтаар орно.

[3] Ингэхдээ аялагчийн паспорт 6 сарын хугацаанд хүчинтэй хугацаа нь дуусахааргүй байх, аяллын даатгал хийлгэх шаардлага шинээр тавигдаж байна.

[4] Их Британи 2019 оны байдлаар нийт үйлчилгээний экспортын 42 хувийг Евро бүсэд нийлүүлжээ. Үүнд архитектур, инженер, хуулийн зөвлөх, нягтлан бодох, зар сурталчилгаа, судалгаа хөгжүүлэлт бусад мэргэжлийн болон техникийн зөвлөх үйлчилгээ нь

санхүүгийн харилцааг зохицуулах нэмэлт журам, зохицуулалтууд шаардлагатай болно.

- **Гадаад худалдааны гаалийн мэдүүлэг бүрдүүлдэг болно.** Худалдааны хэлэлцээрээр талууд барааны экспорт, импортод тэг тариф, тэг квот тогтоох зөвшилцөлд хүрсэн боловч экспортлогчид, импортлогчид бараг хилээр нэвтрүүлэхэд гаалийн мэдүүлэг бөглөх, шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлдэг болно[5]. Ингэснээр бараа, бүтээгдэхүүнийг хилээр шалган нэвтрүүлэх процесс илүү удааширч, гадаад худалдааны эргэлт буурч болзошгүй.

Их Британи болон ЕХ худалдааны хэлэлцээрт хүрсэн нь Брекситийн дараах эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах хэдий ч ЕХ-ноос гарсны үр дагаварт Их Британийн эдийн засгийн өсөлт ирэх 10 жилийн туршид ЕХ-ноос гараагүй байснаас жил бүр 0.5 нэгж хувиар бага байна гэж Блүмбергийн эдийн засагчид тооцоолж байна.

<u>Нэмэлт тайлбар:</u>

* ЕХ-ны тухай гэрээний 50 дугаар зүйлд (Article 50): “Европын Холбооны аливаа гишүүн улс өөрийн үндсэн хуулийн шаардлагын дагуу холбооноос гарах шийдвэр гаргаж болно” гэж заасан байдаг.

* “Chequers Plan” - Энэ нь Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэйийн өргөн барьж, 2018 оны 7-р сард батлуулсан “Их Британи болон ЕХ-ны ирээдүйн харилцаа”-ны талаарх баримт бичиг юм. Үүнд Их Британи аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн худал даан дээр ЕХ-ны тогтоосон дүрмийн дагуу явах бөгөөд ЕХ-ны бүх төрлийн хоол хүнс, уух зүйлсийг худалдаалж болох нийт 500 сая хэрэглэгчтэй (EU’s Single Market) зах зээлд нэвтрэх боломжийг олгоно гэсэн үг юм. БНИУ болон Умард Ирландын хил дээрх гаалийн хяналтыг сулруулж, “гаалийн нэгдсэн нутаг дэвсгэр" буюу тарифгүй бүс хэлбэрээр ажиллана. Их Британи руу чиглэсэн бараа бүтээгдэхүүний тариф, худалдааны бодлогыг Их Британи өөрөө хариуцах бөгөөд ЕХ-ны өмнөөс тухайн улсаар дамжиж байгаа бараанд татвар хураамж авах юм. Ингэснээр, Их Британи бусад улс орнуудтай бие даасан худалдааны гэрээ байгуулах боломжийг олгох юм.

Евро бүс рүү хийдэг голлох үйлчилгээний экспортыг бүрдүүлдэг.

[5] Ковид-19-ийн нөхцөлтэй холбоотойгоор Их Британи йн ЗГ-аас 2021 оны 1-р сарын 1-ээс зарим нэр төрлийн бараг шалган нэвтрүүлж эхлэх, 2021 оны 7-р сарын 1-ээс бүх төрлийн бараг шалган нэвтрүүлэх байдлаар хугацааг сунгаад байгаа бол Европын холбоо 2021 оны 1-р сарын 1-ээс бүх төрлийн бараг шалган нэвтрүүлэхээр байна.